СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Дарьганга сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

СБА-2022/39/НА-СТА-ТШЗ

---


Тэргүүлэх аудитор: М.Нарантуяа

Утас: 70518369 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Даваа

Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунзул

Утас: 70512127 Цахим хаяг: Ariunzulb@audit.gov.mn


Цахим хуудас: www.audit.mn

Баруун-Урт сум

2022 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 11
3. Аудитын тайлан ........ 13
3.1 Ерөнхий зүйл ........ 13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 13
3.4 Материаллаг байдал ........ 14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 15
3.8 Аудитын гол асуудал ........ 15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ **Error! Bookmark not defined.**
4. Аудитын илрүүлэлт ........ 16
4.1 Зөвлөмж ........ 16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 17

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.02.25 № 89

танай ____________-ны №______________-т

СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.МӨНХЗУЛ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дарьганга сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дарьганга сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.НАРАНТУЯА

# 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **141,770,942.25** | **134,092,062.32** |
| **33** | **АВЛАГА** | 15,033,375.00 | 32,019,815.00 |
| **335** | **Бусад авлага** | 15,033,375.00 | 32,019,815.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 15,033,375.00 | 32,019,815.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 126,737,567.25 | 102,072,247.32 |
| **354** | **Хангамжийн материал** | 42,347,267.25 | 26,416,947.32 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,728,720.00 | 1,729,825.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 25,251,147.25 | 8,739,622.32 |
| 35450 | Барилгын засварын материал | 37,400.00 | 7,300.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 14,330,000.00 | 15,940,200.00 |
| 35500 | Биологийн хөрөнгө | 59,785,300.00 | 59,785,300.00 |
| 35600 | Мал амьтад | 24,605,000.00 | 15,870,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **931,929,796.08** | **950,711,261.62** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 931,929,796.08 | 950,711,261.62 |
| **392** | **Биет хөрөнгө** | 926,905,796.08 | 945,867,261.62 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 586,533,050.00 | 600,915,520.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -42,799,483.80 | -56,716,475.52 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 306,059,350.00 | 308,190,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -176,371,849.99 | -201,224,722.22 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 79,617,863.68 | 64,158,189.60 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -38,128,854.83 | -30,456,842.61 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 96,579,471.57 | 86,229,894.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -55,562,273.59 | -49,115,115.36 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 43,308,600.00 | 43,308,600.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | -15,684,697.13 | -18,605,871.41 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 273,399,125.00 | 338,537,561.50 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -130,044,504.83 | -139,353,476.36 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 5,024,000.00 | 4,844,000.00 |
| 39301 | Програм хангамж | 950,000.00 | 950,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -350,000.00 | -500,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 4,604,000.00 | 4,604,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -180,000.00 | -210,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,073,700,738.33** | **1,084,803,323.94** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **17,013,953.92** | **32,054,215.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 17,013,953.92 | 32,054,215.00 |
| **413** | **Өглөг** | 17,013,953.92 | 32,054,215.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 588,083.92 | 34,400.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 16,425,870.00 | 32,019,815.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 15,380,000.00 | 30,369,815.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 1,045,870.00 | 1,650,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,056,686,784.41** | **1,052,749,108.94** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,056,686,784.41 | 1,052,749,108.94 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 611,477,502.24 | 611,477,502.24 |

| | | | |
|---|---|---|---|
| 51101 | Өмч: - төрийн | 611,477,502.24 | 611,477,502.24 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 395,123,140.32 | 394,275,248.37 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 395,123,140.32 | 398,212,923.84 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -3,937,675.47 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 50,086,141.85 | 46,996,358.33 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,073,700,738.33** | **1,084,803,323.94** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **720,496,442.00** | **765,111,105.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **190,735,114.00** | **122,561,036.50** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 190,735,114.00 | 122,561,036.50 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 190,735,114.00 | 122,561,036.50 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 13,900,000.00 | 14,050,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 176,835,114.00 | 108,511,036.50 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **529,761,328.00** | **642,550,068.50** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 47,437,928.00 | 139,916,068.50 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 5,769,872.00 | 4,869,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 37,800,000.00 | 117,139,641.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,198,056.00 | 1,098,827.50 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 670,000.00 | 16,808,600.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 482,323,400.00 | 502,634,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 482,323,400.00 | 502,634,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **623,691,036.72** | **766,577,098.93** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **623,691,036.72** | **766,577,098.93** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 598,909,167.84 | 692,743,712.22 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 233,446,891.20 | 257,254,671.90 |
| 210101 | Үндсэн цалин | 233,446,891.20 | 236,804,671.90 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 4,370,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 16,080,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 29,870,873.68 | 33,731,407.38 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,959,174.64 | 23,601,304.10 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,184,401.25 | 2,625,546.02 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,104,902.26 | 2,060,116.55 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 238,400.00 | 494,949.18 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,383,995.53 | 4,949,491.53 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 25,552,192.64 | 38,651,992.59 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,276,400.64 | 4,962,600.59 |
| 210302 | Түлш, халаалт | 22,275,792.00 | 22,325,792.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 11,363,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 43,798,141.00 | 58,718,679.93 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,982,361.00 | 2,765,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 37,267,730.00 | 28,114,270.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,980,000.00 | 1,898,390.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 568,050.00 | 744,100.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 25,196,819.93 |
| **2105** | **Нормативт зардал** | 4,265,000.00 | 367,200.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,244,000.00 | 53,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | 972,000.00 | 313,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,049,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,947,900.00 | 7,893,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 10,527,900.00 | 1,303,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,420,000.00 | 6,590,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,172,000.00 | 2,939,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 2,200,000.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,972,000.00 | 2,939,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 34,932,580.00 | 48,687,590.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 33,474,580.00 | 47,625,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 540,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 500,000.00 | 500,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 150,000.00 | 312,125.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 250,000.00 | 243,025.00 |
| 210807 | Газрын төлбөр | 18,000.00 | 7,440.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 209,923,589.32 | 244,499,270.42 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 129,188,809.00 | 160,726,981.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 80,734,780.32 | 83,772,289.42 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 24,781,868.88 | 73,833,386.71 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 7,936,228.00 | 15,690,242.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 6,511,038.00 | 5,953,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 7,813,242.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,425,190.00 | 1,924,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 16,845,640.88 | 58,143,144.71 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **96,805,405.28** | **-1,465,993.93** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | 10,000,000.00 | 00.00 |
| 145002 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз | 10,000,000.00 | 00.00 |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 2,471,681.54 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 2,471,681.54 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 10,000,000.00 | -2,471,681.54 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **106,805,405.28** | **-3,937,675.47** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 607,173,502.24 | 1,773,008.93 | 946,466,804.52 | 00.00 | 1,555,413,315.69 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **607,173,502.24** | **1,773,008.93** | **946,466,804.52** | **00.00** | 1,555,413,315.69 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 4,304,000.00 | 00.00 | -808,791,108.55 | 00.00 | -804,487,108.55 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **611,477,502.24** | **50,086,141.85** | **395,123,140.32** | **00.00** | 1,056,686,784.41 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **611,477,502.24** | **50,086,141.85** | **395,123,140.32** | **00.00** | 1,056,686,784.41 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 3,089,783.52 | 00.00 | 3,089,783.52 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **611,477,502.24** | **50,086,141.85** | **398,212,923.84** | **00.00** | 1,059,776,567.93 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -3,089,783.52 | 00.00 | 00.00 | -3,089,783.52 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -3,937,675.47 | 00.00 | -3,937,675.47 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **611,477,502.24** | **46,996,358.33** | **394,275,248.37** | **00.00** | 1,052,749,108.94 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **545,161,328.00** | **656,600,068.50** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **13,900,000.00** | **14,050,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 13,900,000.00 | 14,050,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 13,900,000.00 | 14,050,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 13,900,000.00 | 14,050,000.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **531,261,328.00** | **642,550,068.50** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 48,937,928.00 | 139,916,068.50 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 5,769,872.00 | 4,869,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 39,300,000.00 | 117,139,641.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,198,056.00 | 1,098,827.50 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 670,000.00 | 16,808,600.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 482,323,400.00 | 502,634,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 482,323,400.00 | 502,634,000.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **516,920,348.00** | **644,482,068.50** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **516,920,348.00** | **644,482,068.50** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **477,651,442.12** | **570,648,681.79** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 230,997,041.28 | 257,843,050.82 |
| 210101 | Үндсэн цалин | 230,997,041.28 | 237,393,050.82 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 4,370,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 16,080,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 30,277,926.20 | 33,731,407.38 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,263,000.16 | 23,601,304.10 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,980,391.25 | 2,625,546.02 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,187,773.26 | 2,060,116.55 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 460,396.00 | 494,949.18 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,386,365.53 | 4,949,491.53 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 25,385,445.64 | 37,782,132.59 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,109,653.64 | 4,142,740.59 |
| 210302 | Түлш, халаалт | 22,275,792.00 | 22,275,792.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 11,363,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 28,517,850.00 | 28,787,160.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,953,461.00 | 3,558,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 22,016,339.00 | 22,016,970.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,980,000.00 | 1,773,390.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 568,050.00 | 1,438,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 4,265,000.00 | 367,200.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,244,000.00 | 53,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | 972,000.00 | 313,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,049,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,071,900.00 | 8,585,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 9,651,900.00 | 1,758,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,420,000.00 | 6,826,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,252,000.00 | 2,939,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 2,200,000.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,052,000.00 | 2,939,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 39,022,580.00 | 51,408,590.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 37,564,580.00 | 50,346,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 540,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 500,000.00 | 500,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 150,000.00 | 312,125.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 250,000.00 | 243,025.00 |
| 210807 | Газрын төлбөр | 18,000.00 | 7,440.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 102,861,699.00 | 149,204,741.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 102,861,699.00 | 149,204,741.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **39,268,905.88** | **73,833,386.71** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 7,423,560.00 | 15,690,242.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 5,854,560.00 | 5,953,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 6,313,242.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,569,000.00 | 3,424,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 31,845,345.88 | 58,143,144.71 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 31,845,345.88 | 58,143,144.71 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **28,240,980.00** | **12,118,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **28,240,980.00** | **12,118,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **28,240,980.00** | **12,118,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 28,240,980.00 | 12,118,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 28,240,980.00 | 12,118,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-28,240,980.00** | **-12,118,000.00** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 00.00 | 00.00 | 520,387,200.00 | 490,560,670.29 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 00.00 | 00.00 | 520,387,200.00 | 490,560,670.29 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 00.00 | 00.00 | 506,120,500.00 | 476,370,428.29 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 00.00 | 00.00 | 270,210,600.00 | 257,514,550.82 |
| 210101 | Үндсэн цалин | 00.00 | 00.00 | 247,634,600.00 | 237,064,550.82 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 00.00 | 6,496,000.00 | 4,370,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 00.00 | 16,080,000.00 | 16,080,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 00.00 | 00.00 | 34,065,900.00 | 33,687,059.88 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 00.00 | 00.00 | 23,676,500.00 | 23,556,956.60 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 00.00 | 2,296,400.00 | 2,625,546.02 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 00.00 | 2,378,800.00 | 2,060,116.55 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 00.00 | 519,500.00 | 494,949.18 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 00.00 | 5,194,700.00 | 4,949,491.53 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 00.00 | 00.00 | 27,452,800.00 | 26,493,532.59 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 00.00 | 00.00 | 4,976,700.00 | 4,017,740.59 |
| 210302 | Түлш, халаалт | 00.00 | 00.00 | 22,276,100.00 | 22,275,792.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 00.00 | 200,000.00 | 200,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 00.00 | 00.00 | 31,000,000.00 | 27,120,780.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 00.00 | 00.00 | 4,000,000.00 | 3,293,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 00.00 | 00.00 | 23,000,000.00 | 20,215,590.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 00.00 | 00.00 | 2,000,000.00 | 1,613,390.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 00.00 | 00.00 | 2,000,000.00 | 1,998,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 00.00 | 00.00 | 10,800,000.00 | 9,813,400.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 00.00 | 5,300,000.00 | 4,338,900.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 00.00 | 1,500,000.00 | 1,498,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 00.00 | 4,000,000.00 | 3,976,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 00.00 | 00.00 | 3,422,600.00 | 2,939,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 00.00 | 3,422,600.00 | 2,939,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 00.00 | 00.00 | 59,168,600.00 | 57,968,590.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 00.00 | 58,070,600.00 | 56,906,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 00.00 | 500,000.00 | 500,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 00.00 | 00.00 | 330,000.00 | 312,125.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 00.00 | 250,000.00 | 243,025.00 |
| 210807 | Газрын төлбөр | 00.00 | 00.00 | 18,000.00 | 7,440.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 0.00 | 0.00 | 70000000.00 | 60833515.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 00.00 | 70,000,000.00 | 60,833,515.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 0.00 | 0.00 | 14266700.00 | 14190242.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 00.00 | 14,266,700.00 | 14,190,242.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 00.00 | 00.00 | 5,953,400.00 | 5,953,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 00.00 | 6,313,300.00 | 6,313,242.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 00.00 | 2,000,000.00 | 1,924,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 00.00 | 00.00 | 515,634,000.00 | 494,385,079.29 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 00.00 | 00.00 | 10,000,000.00 | 00.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 00.00 | 00.00 | 10,000,000.00 | 00.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 00.00 | 00.00 | 492,634,000.00 | 480,335,079.29 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 00.00 | 00.00 | 492,634,000.00 | 480,335,079.29 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 00.00 | 00.00 | 13,000,000.00 | 14,050,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 00.00 | 13,000,000.00 | 14,050,000.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 00.00 | 00.00 | 23.00 | 23.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 00.00 | 00.00 | 07.00 | 07.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 00.00 | 00.00 | 13.00 | 13.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 00.00 | 00.00 | 03.00 | 03.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баруун-Урт сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-аас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ариунзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Дарьганга сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дарьганга сумын ЗДТГ нь Төр засгийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн, бодлого шийдвэр зохицуулалт, үйлчилгээгээр ханган төрийн захиргааны удирдлагын манлайлал, үйл ажиллагааны үр нөлөө,үр ашгийг дээшлүүлэх хуулиа дээдэлсэн, ил тод байдалд суурилсан хөгжлөөрөө манлайлсан улс аймгийн тэргүүний сум болох эрхэм зорилго тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дарьганга сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн нь хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд нийт ажил гүйлгээний ихэнх хувийг зардлын гүйлгээ эзэлдэг бөгөөд төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байдлыг татвар төлөгч, иргэд илүү анхаардаг учир материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 644.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 9.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 6.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дарьганга сумын ЗДТГ нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 24.7 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая.төг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| **Б** | 1 | 2 | 3=2-1 |
| **Мөнгөн хөрөнгө** | 0 | 0 | 0 |
| **Авлага** | 0 | 0 | 0 |
| **Бараа материал** | 126.7 | 102.0 | -24.7 |
| **Үндсэн хөрөнгө** | 931.9 | 950.7 | 18.8 |
| **Нийт хөрөнгө** | **1,073.7** | **1,084.8** | **11.1** |
| **Өр төлбөр** | 17.0 | 32.0 | 15 |
| **Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/** | 1,056.6 | 1,052.7 | 3.9 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,073.7** | **1,084.8** | **11.1** |

Бараа материалын дансны үлдэгдэл 102.0 сая төгрөг болж 24.7 сая төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 950.7 сая төгрөг болж 18.8 сая төгрөгөөр буурсан байна. Төсвийн хөрөнгөөр 12.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авч, авто тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл акталсан байна.

Дарьганга сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 765.1 сая төгрөг буюу 5.8 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь хандив тусламжийн орлого, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын данс байна. Тодруулбал тайланд онд өмнөх оны үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 68.3 сая төгрөгөөр буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 766.5 сая төгрөг буюу 18.6 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс болон нэмэгдэл, АО-оос НД шимтгэлийн зардал, урсгал зардал, томилолтын зардал, бараа ажил үйлчилгээний бусад зардлууд байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 634.3 сая төгрөгөөр, нийт зарлагыг 630.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийг 634.3 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 634.3 сая төгрөгийн төсөв батласнаас 480.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 634.3 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 630.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Дарьганга сумын ЗДТГ нь 2021 онд гүйцэтгэлийн төлөвлөөгөөр 4 зорилт дэвшүүлэн ажиллаж 80.1 хувьтай хэрэгжсэн байна.

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Дарьганга сумын ЗДТГ-ын үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах асуудал гараагүй.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 140 мэдээллээс хугацаандаа оруулсан 141, хугацаа хоцроож мэдээлсэн 9 мэдээлэл байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн,бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 19.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 19.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, үндсэн хөрөнгөтэй холбоотой зөвлөмж өгсөн.

### 4.1 Албан шаардлага

*1.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн данстай холбоотой*

Санхүүгийн тайланд аудит хийхэд хөрөнгө худалдан авахад 12.1 сая, тэмцээн уралдаан зохион байгуулахад 7.7 сая, нийт 19.8 сая төгрөг зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;/, 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;/ Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4, 1.5 -д заасныг тус тус зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгсөн.

### 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал***

<u>*1.1. Илрүүлэлт:*</u>

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 48 ширхэг 35.8 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна", 6.2.1-д "Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид

зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон”, “үнэлгээ ба хуваарилалт”, “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*1.2. Өгсөн зөвлөмж:*

Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд санал гаргаж, эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх

***2.Шилэн данстай холбоотой асуудал***

*2.1 Илрүүлэлт:*

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудаст нийт 140 мэдээллийг ил тод байршуулахаас 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-т заасан “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*2.1 Өгсөн зөвлөмж:*

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Дарьганга сумын ЗДТГ | 3 | 19.8 | - | - | - | - | 1 | 19.8 | 2 | - |
| | | | | | | | | | | | |